

Банкны салбарын эргэн тойронд

07.01 – Үндэсний хөрөнгө оруулалтын банк өөрийн нэрийн төгрөгийн олон улсын виза картыг шинээр зах зээлд нэвтрүүллээ. Энэ карт нь зөвхөн төгрөгийн данстай боловч харилцагч бусад валютаар тооцоо хийх үед тухайн үеийн ханшаар хөрвөдөг онцлогтой. www.nibank.mn/mn

07.06 - Их Британийн “Олон улсын банк санхүүгийн тойм” (“Global banking & finance review”) байгууллагаас жил бүр шалгаруулдаг дэлхийн банк, санхүүгийн салбарын шилдгүүд тодорч, Худалдаа, хөгжлийн банк 2016 оны “Монгол Улсын шилдэг арилжааны банк”-аар 5 дахь жилдээ дахин шалгарлаа. tdbm.mn

07.18 – Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2016 оны 7 дугаар сарын 7 болон 8 өдрүүдэд хуралдаж бодлогын хүүг өөрчлөлгүй хэвээр хадгалах шийдвэр гаргалаа. mongolbank

07.20 – Улсын Их Хурлын анхдугаар чуулганы нэгдсэн хуралдаанаар Монголбанкны Ерөнхийлөгч Найдансүрэнгийн Золжаргалыг хүсэлтийн дагуу үүрэгт ажлаас нь чөлөөлж Надмидын Баяртсайханыг Монголбанкны Ерөнхийлөгчөөр томиллоо. mongolbank

07.21 - ОХУ-ын Санкт-Петербург хотноо 2016 оны 7 дугаар сарын 13-наас 15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Олон улсын банкуудын 21 дүгээр бага хурал”-д Монголбанк, ОХУ-ын төв банк, Монгол Улсын арилжааны банкуудтай хамтран амжилттай оролцлоо. mongolbank

07.29 – 11 дэх удаагийн АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтын үеэр Худалдаа, хөгжлийн банк, БНХАУ-ын Хөгжлийн банкттай төслийн санхүүжилтанд ашиглагдах 20 сая ам.долларын зээлийн гэрээнд гарын үсэг зурлаа. tdbm.mn

08.18 - Монголбанкны Захирлуудын зөвлөлийн 2016 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн хурлаас бодлогын хүүг 4.5 нэгж хувиар нэмэгдүүлэн 15 хувьд хүргэх шийдвэрийг гаргалаа. mongolbank

08.22 – Голомт банк дараа төлбөрт Зэс кредит картыг зах зээлд нэвтрүүллээ. golomtbank.com

08.25 – Хас банкны “Дата төв” олон улсын TIER II стандартыг хангаж, батламж авлаа. Хас банкны хувьд харилцагчдын мэдээллийн аюулгүй байдлыг илүү өндөр түвшинд хангах зорилгоор “Дата төв”-өө шинэчлэх ажлыг өнгөрсөн онд эхлүүлэн энэ оны 7-р сард дуусгасан. xacbank.mn

09.01 - 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Э.Батшугарыг үүрэгт ажлаас нь чөлөөлж, Б.Лхагвасүрэнг томилов. mongolbank.mn


09.07 – Хаан банк байгууллагын ам.долларын шаталсан хүүт харилцах дансны жилийн хүүг 2016 оны 10 сарын 07-ноос шинэчлэж байна. 500-9999 долларын харилцахад жилийн 0%, 10,000-49,999 долларын харилцахад жилийн 1,0%, 50,000-с дээш харилцахад 2,0%-н хүүг тус тус тооцно.

09.10 – Худалдаа, хөгжлийн банк БНХАУ-ын Баошан банкттай 300 сая Юанийн банк хоорондын шууд зээлийн гэрээнд гарын үсэг зурснаар иргэд болон аж ахуй нэгжүүдэд бага хүүтэй, тааламжтай нөхцөл бүхий Юанийн зээлийг шуурхай олгох боломж бүрдэж байна. tdbm.mn

09.13 – Төрийн банкны ТУЗ-ийн 2016 оны 9-р сарын 13-ны өдрийн тогтоолоор Төрийн банкны Ерөнхий захирлаар Д.Баярсайхан, Гүйцэтгэх захирлаар Б.Цэндсүрэн нарыг томилсон байна. www.statebank.mn


09.30 - Европын сэргээн босголт хөгжлийн банкны (ЕСБХБ) Тэргүүн дэд ерөнхийлөгч бөгөөд Үйл ажиллагаа хариуцсан захирал Филип Бэннэт тэргүүтэй төлөөлөгчид 2016 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр ХасБанканд ЕСБХБ-ны Монголд хэрэгжүүлсэн анхны төслийн хамтран ажиллагч байгууллага хэмээн батламж гардууллаа. xacbank.mn

Банкны салбарын гол үзүүлэлтүүд




Нийт актив = 24,6 их наяд төгрөг

Банкны салбарын нийт актив 2016 оны 3-р улиралд 24,6 их наяд төгрөг болж өмнөх улирлаас даруй 1,3 их наяд төгрөгөөр өслөө. Энэ нь өмнөх оны мөн үеэс 15,5% өссөн үзүүлэлт юм. 2015 оны 3-р улирлаас хойш улирал бүр банкны салбарын нийт актив өслөө.




Чанаргүй зээл 7,4%-д хүрлээ

Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь 2014 оны 2-р улирлаас хойш 2016 оны 3-р улирал хүртэл тогтмол өслөө. 2014 оны 2-р улиралд чанаргүй зээл 2,8% байсан бол 2016 оны 3-р улиралд 7,4% буюу 2,7 дахин ихэсжээ. Нийт дүнгээр авч үзвэл нийт чанаргүй зээл 0,9 их наяд төгрөгт хүрээд байна.



Ипотекийн зээл = 3,9 их наяд төгрөг

Нийт ипотекийн зээл 3,9 их наяд төгрөг хүрсэнээс орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр(ОСИСТТБ)-н дагуу 3 их наяд төгрөгний зээл олгосон байна. Ипотекийн зээлийн хэмжээ тогтмол өссөөр байна.



Харилцах+Хадгаламж=10,7 их наяд ₮


Нийт банкны салбарын харилцах ба хадгаламжийн нийлбэр өмнөх оны мөн үеэс 13,8% буюу 1,3 их наяд төгрөгөөр өсөөд байна. Өмнөх мөн үеэс харилцах ба хадгаламжийн нийлбэр дүн улирал бүр тогтмол өсчээ.

БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2016 он – III улирал


Валют(Харилцах + Хадгаламж) = 3,82 их наяд ₮

Банкны салбарын валютын харилцах болон хадгаламжийн хэмжээ өмнөх улиралтай харьцуулахад валютын харилцах 34.6%-иар харин валютын хадгаламж 15,2%-иар өссөн байна. Нийт валютын харилцах ба хадгаламжийн нийлбэр өмнөх оны мөн үеэс 21,6% өсөж 3,82 их наяд төгрөгт хүрээд байна.




1\$=2434₮ 1¥=336₮

Монголбанкнаас зарласан ханшийн сарын дундаж хөдөлгөөнөөр 2016 оны 6 сарын дундаж Ам.доллар-ын ханш 2434₮ болж огцом өссөн бол Юань-ийн ханш 336₮ байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад Ам.доллар 469₮-р, Юань 38₮-р өссөн үзүүлэлт юм. Энэхүү ханшийн огцом өсөлтөөс үүдэн Монголбанк бодлогын хүүг 15% болгож өсгөсөн.



Ашиг = 89 тэрбум төгрөг

Банкуудын өөрийн хөрөнгө 2016 оны 3-р улирлын байдлаар 2,9 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 15.5% өслөө. 2016 оны 3-р улирлын байдлаар банкны салбарын ашиг 89 тэрбум төгрөг байгаа нь мөн оны өмнөх үеэс 2 дахин бага үзүүлэлт юм.



Банкны нөөц = 2.6 их наяд төгрөг

Банкны нөөц 2016 оны 1 сараас 6-р сар хүртэл тогтмол өсч 3 их наяд төгрөгт хүрээд байсан хэдий ч 9-р сарын байдлаар 2,6 их наяд төгрөг хүрч буурлаа. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24% өссөн үзүүлэлт юм.



Банкуудын өрсөлдөөн

Арилжааны банкны үндсэн үүрэг нь мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй байгаа хэсгээс хөрөнгийг татаж, дутагдалтай байгаа хэсэгт шилжүүлэн, харилцагчдын итгэл дээр суурилсан санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа үзүүлэх, харилцагчдын хоорондын төлбөр тооцоог хийж гүйцэтгэх бөгөөд эцсийн зорилго нь санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан ашиг олох явдал билээ.

2016 оны 3-р улирлын байдлаар банкны салбарт нийт 14 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Монголбанкны тодорхойлсноор системд нөлөө бүхий банкуудад Хаан банк, ХХБ, Голомт банк, Хасбанк, Төрийн банк, Улаанбаатар хотын банк гэсэн 6 банк багтаж байна. Эдгээр банкууд нь системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж буй юм.

Арилжааны банкуудын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өөрчлөлт хөдөлгөөнийг харуулдаг мэдээллийн гол эх сурвалж бол банкуудын санхүүгийн тайлан юм. Банкуудын өрсөлдөөний тоймыг гаргахдаа санхүүгийн хураангуй тайланг ашиглан дараах үзүүлэлтүүдийг харьцуулсан болно. Үүнд:

- Нийт актив
- Зээл
- Харилцах, хадгаламж
- Ашиг

Эдгээр үзүүлэлтээр арилжааны банкуудыг харьцуулахдаа активын хэмжээгээр нь Том-3 банк, Дунд-3 банк, бусад банкууд гэж ангилсан

Энэ удаагийн тайланд Капитал болон Тээвэр хөгжлийн банкны мэдээлэл ороогүй болно.





АКТИВ

БАНКУУД

ТОМ-3 БАНК	>3 их наяд төгрөг	Худалдаа хөгжлийн банк Хаан банк Голомт банк
ДУНД-3 БАНК	1-3 их наяд төгрөг	Хасбанк Төрийн банк Улаанбаатар хотын банк
БУСАД БАНКУУД	<1 их наяд төгрөг	Капитал банк Чингис хаан банк Капитрон банк Үндэсний хөрөнгө оруулалтын банк Ариг банк Богд банк Кредит банк Тээвэр хөгжлийн банк


Банкны төлбөрийн системийн талаар

Монголбанкнаас гаргадаг төлбөрийн системийн тайлангаас зарим мэдээллийг онцлон хүргэж байна.



Монгол Улсад 2016 оны 3-р улиралын байдлаар 3,9 сая карт ашиглагдаж байгаагаас 1,4 сая карт идэвхтэй ашиглагдаж байна. Энэхүү үзүүлэлт нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад харгалзан 3% болон 20%-иар буурсан үзүүлэлт юм.

Монгол Улсын хэмжээнд олон улсын Visa, Master, UPI(Union Pay international) болон төгрөгийн төрлийн картууд ихээр ашиглагдаж байна. Төгрөгийн карт хамгийн олон буюу 2,7 сая “төгрөгийн” карт ашиглагдаж байна. Төгрөгийн болон UPI картны тоо жил ирэх бүр нэмэгдэж байгаа бол Visa болон Master картны тоо жил ирэх бүр буурч байна.



Төлбөрийн системд Пос, МПОС, ПОБ терминалууд болон АТМ төхөөрөмжийг үйлчлүүлэгчид хэрэглэж байна. Банкны төхөөрөмжийн хэрэглээ тогтмол өссөөр байна. Пос терминалын хувьд 2014 оны 3-р улиралд 11,4 мянган ширхэг байсан бол 2016 3-р улиралд 20,1 мянга буюу 77%-иар өссөн байна. Мөн АТМ-ын тоо 2016 оны 3-р улиралд 1762 ширхэг байгаа нь 2 жилийн өмнөхөөс 50%-иар өссөн дүн юм.

		3У'14	3У'15	3У'16
Пос терминал	Дүн	277,6	477	554
	Тоо	5,6	10,1	17,9
МПОС терминал	Дүн	0,3	1,6	2
	Тоо	0,01	0,1	0,2
ПОБ терминал	Дүн	242,3	47,5	50,1
	Тоо	0,6	0,2	0,2
АТМ төхөөрөмж	Дүн	1531,8	1620,9	2952,5
	Тоо	30	31,3	21,3


Пос терминалаар 17,9 сая удаа, 554 тэрбум төгрөгний гүйлгээ хийгдэж нэг гүйлгээний дундаж дүн нь 31 мянган төгрөг байна. АТМ төхөөрөмжөөр 21,3 сая удаа, 2,9 их наяд төгрөгийн гүйлгээ хийгдэж нэг гүйлгээний дундаж дүн нь 139 мянган төгрөг байна. Нийт төхөөрөмжүүдээр 39,5 сая удаа нийт 3,5 их наяд төгрөгийн гүйлгээ хийгджээ.

АКТИВ


Тайлант хугацаанд тайланд орсон нийт банкны 12 банкны актив 24 их наяд төгрөгт хүрлээ. Том-3 банк нийт активын 73 хувь буюу өмнөх улирлаас 1.4 нэгжээр нэмэгдсэн бол Дунд-3 банк 23 хувь, жижиг банкууд 4 хувийг эзэлж байна.

ХХБ 6,8 их наяд төгрөгийн актив буюу хамгийн их нь байгаа бол Кредит банк 17 тэрбум төгрөгийн актив буюу хамгийн бага нь байна.


Зах зээлд эзлэх хувь, активаар, 3У'16



Банкуудын активын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлтийн хувь



Жижиг банкууд




ЗЭЭЛ

Тайланд орсон 12 банкны нийт зээл 11,5 их наяд төгрөгт хүрлээ. Үүнээс 71%-г Том-3 банк, 25%-г Дунд-3 банк, 4%-г жижиг банкууд бүрдүүлж байна.

ХХБ хамгийн их зээл буюу 3,2 их наяд төгрөгний зээл олгосон байна. ХХБ-ны зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20% өсөөд байна.


Харин нийт системийн зээл олголт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5,6%-иар өсжээ.

Зах зээлд эзлэх хувь, 3У'16




Зээлийн хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлтийн хувь


Том-3, тэрбум төгрөгөөр



Дунд-3, тэрбум төгрөгөөр




Жижиг банкууд





ХАДГАЛАМЖ БА ХАРИЛЦАХ

Тайланд орсон нийт 12 банкны харилцах ба хадгаламжийн 71,2%-г Том-3 банк, 25%-г Дунд-3 банк, 3,8%-г бусад 6 жижиг банкууд эзэлж байна.

Харилцах ба хадгаламжийн нийт дүнгээр Хаанбанк 31,1%-г эзэлж буй нь тэргүүлэх үзүүлэлт юм. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад салбарын хадгаламж ба харилцах 15,4%-иар өслөө.




Хадгаламж ба харилцахын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлт



АШИГ

2016 оны 3-р улирлын байдлаар тайланд орсон 12 арилжааны банкуудын санхүүгийн тайлангийн нийлбэр дүнгээр банкууд нийт 137 тэрбум төгрөгийн ашигтай (татвар төлөхийн өмнөх дүн) ажиллажээ. Энэ дүн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 44 хувь буурсан үзүүлэлт юм.

Банкуудын ашиг, алдагдал:



Эх үүсвэр:

1. Статистикийн бюллетень, Монголбанк
2. Ипотекийн зээлийн тайлан, Монголбанк
3. Банкуудын нэгдсэн балансын гол үзүүлэлтүүд, Монголбанк
4. Төлбөрийн системийн тайлан, Монголбанк
5. Монголбанкны ханшийн сарын дундаж хөдөлгөөн, Монголбанк
6. Арилжааны банкуудын улирлын санхүүгийн тайлан